



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Заг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2026/017/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор
2026 оны 02 дугаар сарын 25

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер: М.Алтантуяа
Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Нарангэрэл Утас:99009293 Цахим
хаяг: Narangerelb@audit.gov.mn, 99009293

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАГ
СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
С.ТУЯАЦЭЦЭГ ТАНАА**

2026.02.25 № 2/91
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Заг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар тодорхой бус байдал нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Баянхонгор аймгийн Заг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 6 зорилтын хүрээнд 35 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг сумын Засаг дарга 96.2 хувиар үнэлсэн байна.

Баянхонгор аймгийн Заг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>6,085,200.00</u>	<u>6,737,500.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	<u>6,085,200.00</u>	<u>6,737,500.00</u>
351	Түүхий эд материал	<u>3,748,900.00</u>	<u>3,823,900.00</u>
35110	Тусгай зориулалттай материал	3,748,900.00	3,823,900.00
354	Хангамжийн материал	<u>2,336,300.00</u>	<u>2,913,600.00</u>
35410	Бичиг хэргийн материал	466,800.00	224,100.00
35420	Аж ахуйн материал	99,000.00	99,000.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	700,000.00
35470	Бусад хангамжийн материал	1,770,500.00	1,890,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>28,078,807.10</u>	<u>32,664,524.19</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	<u>28,078,807.10</u>	<u>32,664,524.19</u>
392	Биет хөрөнгө	<u>28,078,807.10</u>	<u>32,664,524.19</u>
39203	Авто-тээврийн хэрэгсэл	18,500,000.00	18,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-2,312,499.96	-4,624,999.92
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	18,280,750.00	18,280,750.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-8,989,649.62	-9,970,732.48
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	6,445,241.00	15,164,241.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-4,445,034.32	-5,284,734.41
39217	Ном	600,000.00	600,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	100,000.00	100,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-100,000.00	-100,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>34,164,007.10</u>	<u>39,402,024.19</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>4,424,100.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>4,424,100.00</u>
413	Өглөг	<u>00.00</u>	<u>4,424,100.00</u>
4136	Бусад өглөг	<u>00.00</u>	<u>4,424,100.00</u>
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	4,424,100.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>34,164,007.10</u>	<u>34,977,924.19</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	<u>34,164,007.10</u>	<u>34,977,924.19</u>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	4,682,100.00	4,682,100.00
51101	Өмч: - төрийн	4,682,100.00	4,682,100.00
512	Хуримтлагдсан үр дүн	<u>28,946,394.64</u>	<u>29,760,311.73</u>
51210	Өмнөх үеийн үр дүн	27,920,184.15	28,946,394.64
51220	Тайлант үеийн үр дүн	1,026,210.49	813,917.09
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	535,512.46	535,512.46
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>32,602,284.15</u>	<u>39,402,024.19</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	192,078,026.50	205,077,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,594,500.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,594,500.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	188,483,526.50	205,077,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,466,326.50	1,800,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	1,800,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,466,326.50	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	178,017,200.00	203,277,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	178,017,200.00	203,277,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	191,051,816.01	204,263,082.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	191,051,816.01	204,263,082.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	168,176,953.17	192,858,901.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	113,970,099.69	137,932,684.11
210101	Үндсэн цалин	59,649,887.37	72,519,599.36
210102	Нэмэгдэл	40,966,995.05	49,026,534.75
210104	Урамшуулал	13,353,217.27	16,386,550.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,110,233.97	15,720,084.62
210201	Тэтгэврийн даатгал	9,585,671.16	11,506,250.24
210202	Тэтгэмжийн даатгал	1,133,813.45	1,312,386.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	600,524.73	645,722.72
210204	Ажилгүйдлийн даатгал	510,823.73	423,726.72
210205	Эрүүл мэндийн даатгал	2,279,400.90	1,831,998.86
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,726,950.00	5,873,600.00
210401	Бичиг хэрэг	2,919,000.00	2,423,600.00
210402	Тээвэр, шатахуун	4,741,250.00	3,450,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	66,700.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	634,880.00	00.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	634,880.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	4,000,000.00	1,920,000.00
210702	Дотоод албан томилолт	4,000,000.00	1,920,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,909,000.00	17,276,250.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,909,000.00	16,676,250.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	600,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,825,789.51	14,136,282.91

Баянхонгор аймгийн Заг сумын ИТХ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	376,600.00	4,293,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,999,900.00	5,710,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,449,289.51	4,133,282.91
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,874,862.84	11,404,181.27
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,661,326.50	1,100,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,661,326.50	1,100,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	11,213,536.34	10,304,181.27
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,175,136.34	10,303,431.27
213404	Хөрөнгийн	38,400.00	750.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,026,210.49	813,917.09
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,026,210.49	813,917.09

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	188,483,526.50	205,077,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	188,483,526.50	205,077,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,466,326.50	1,800,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	1,800,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,466,326.50	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	178,017,200.00	203,277,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	178,017,200.00	203,277,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	188,483,526.50	205,077,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	188,483,526.50	205,077,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	165,608,663.66	194,372,818.73
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	113,970,099.69	137,932,684.11
210101	Үндсэн цалин	59,649,887.37	72,519,599.36
210102	Нэмэгдэл	40,966,995.05	49,026,534.75
210104	Урамшуулал	13,353,217.27	16,386,550.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,110,233.97	15,720,084.62
210201	Тэтгэврийн даатгал	9,585,671.16	11,506,250.24
210202	Тэтгэмжийн даатгал	1,133,813.45	1,312,386.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	600,524.73	645,722.72
210204	Ажилгүйдлийн даатгал	510,823.73	423,726.72
210205	Эрүүл мэндийн даатгал	2,279,400.90	1,831,998.86
2104	Хангамж, бараа материалын зардал	7,607,950.00	5,406,800.00
210401	Бичиг хэрэг	2,800,000.00	1,956,800.00

Баянхонгор аймгийн Заг сумын ИТХ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210402	Тээвэр, шатахуун	4,741,250.00	3,450,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	66,700.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	634,880.00	8,719,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	634,880.00	00.00
210602	Тавилга	00.00	8,719,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,000,000.00	1,920,000.00
210702	Дотоод албан томилолт	4,000,000.00	1,920,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,324,000.00	16,871,250.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,249,000.00	16,871,250.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	75,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,961,500.00	7,803,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	961,600.00	3,293,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,999,900.00	4,510,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,874,862.84	10,704,181.27
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,661,326.50	400,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	9,466,326.50	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,195,000.00	400,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	11,213,536.34	10,304,181.27
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,175,136.34	10,303,431.27
213404	Хөрөнгийн	38,400.00	750.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,682,100.00	535,512.46	27,920,184.15	34,164,007.10
D00	Тайлант үеийн үр дүн	00,00	00,00	1,026,210.49	1,026,210.49
D01	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,682,100.00	535,512.46	28,946,394.64	34,164,007.10
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,682,100.00	535,512.46	28,946,394.64	34,164,007.10
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	813,917.09	813,917.09
D09	2025 оны 12-р	4,682,100.00	535,512.46	29,760,311.73	34,977,924.19

Баянхонгор аймгийн Заг сумын ИТХ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	сарын 31-нээрх үлдэгдэл				
--	-------------------------	--	--	--	--

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	215,186,200.00	192,973,568.73	22,212,631.27	89.7%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	215,186,200.00	192,973,568.73	22,212,631.27	89.7%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	215,186,200.00	192,573,568.73	22,612,631.27	89.5%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	138,121,000.00	137,932,684.11	188,315.89	99.9%
210101	Үндсэн цалин	72,519,600.00	72,519,599.36	0.64	100.0%
210102	Нэмэгдэл	49,106,800.00	49,026,534.75	80,265.25	99.8%
210104	Урамшуулал	16,494,600.00	16,386,550.00	108,050.00	99.3%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,265,200.00	15,720,084.62	1,545,115.38	91.1%
210201	Тэтгэврийн даатгал	11,740,400.00	11,506,250.24	234,149.76	98.0%
210202	Тэтгэмжийн даатгал	1,381,200.00	1,312,386.08	68,813.92	95.0%
210203	ҮОМШӨ- ний даатгал	690,600.00	645,722.72	44,877.28	93.5%
210204	Ажилгүйдлийн даатгал	690,600.00	423,726.72	266,873.28	61.4%
210205	Эрүүл мэндийн даатгал	2,762,400.00	1,831,998.86	930,401.14	66.3%
2104	Хангамж, бараа материалын зардал	8,400,000.00	5,406,800.00	2,993,200.00	64.4%
210401	Бичиг хэрэг	3,300,000.00	1,956,800.00	1,343,200.00	59.3%
210402	Тээвэр, шатахуун	5,000,000.00	3,450,000.00	1,550,000.00	69.0%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	100,000.00	00.00	100,000.00	0.0%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,800,000.00	8,719,000.00	81,000.00	99.1%
210602	Тавилга	8,800,000.00	8,719,000.00	81,000.00	99.1%

Баянхонгор аймгийн Заг сумын ИТХ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2107	Томилолт, зочны зардал	2,900,000.00	1,920,000.00	980,000.00	66.2%
210702	Дотоод албан томилолт	2,900,000.00	1,920,000.00	980,000.00	66.2%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,602,900.00	15,072,000.00	10,530,900.00	58.9%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25,002,900.00	15,072,000.00	9,930,900.00	60.3%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	600,000.00	00.00	600,000.00	0.0%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16600000.00	7803000.00	8,797,000.00	47.0%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,600,000.00	3,293,000.00	3,307,000.00	49.9%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,000,000.00	4,510,000.00	5,490,000.00	45.1%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,500,000.00	400,000.00	2,100,000.00	16.0%
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,500,000.00	400,000.00	2,100,000.00	16.0%
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,000,000.00	00.00	1,000,000.00	0.0%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	400,000.00	1,100,000.00	26.7%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	203,277,000.00	203,277,000.00	0.00	100.0%
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	203,277,000.00	203,277,000.00	0.00	100.0%
132001	Орон нутгийн төсвөөс	203,277,000.00	203,277,000.00	0.00	100.0%
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00		

2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,800,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,800,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,799,250.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,799,250.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,799,250.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	750.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	750.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,800,000.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,800,000.00
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,800,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,196.5 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 1,196.5 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоов.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 1,196.5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайланд хугацааны эцэст татварын байгууллагатай тооцоо нийлэхэд, 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдаагүй татварын ХХОАТ-ын үлдэгдэл өр 1,196.5 мянган төгрөг гарсныг цалингийн зардлаас шилжүүлж барагдуулсан.	1	1,196.5	1	1,196.5				
Дүн	1	1,196.5	1	1,196.5	-	-		

